

МАНУТХГ-ын Хамгаалалтын 2019 оны 02 дугаар сарын 15-ны
өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 01-ний хооронд хийж
хэрэгжүүлсэн ажлын тайлан

2019 оны 03 дугаар
сарын 01-ний өдөр

Өлгий хот

1. Байгаль орчны салбарын удирдах ажилтаны зөвлөлгөөнд тус хамгаалалтын захиргааны дарга С.Медеухан оролцож байна.
2. Аймгийн ЕБС-ийн дэргэлэх “Эко клуб”-ын ахлагч, гишүүдтэй аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хар нуур-Ховд голын сав газрын захиргаатай хамтран уулзалт зохион байгуулж, 2019 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргав. Тус уулзалтанд Монгол Алтайн нурууны УТХГ, ТХГН-ийн үнэ цэнийн талаар мэдээлэл өгөв.
3. Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн 2-р шатны уулзалт, хэлэлцүүлэг Увс аймгийн Улаангом хотод зохион байгуулагдаж байна. Уг зөвлөгөөнд аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэсийн дарга З.Болат, хамгаалалтын захиргааны мэргэжилтэн С.Сакен нар оролцож байна.
4. Сийлхэмийн нурууны БЦГ-ын орчны бүсийн айлын хотонд орсон цоохор ирвэсийг байгальд тавих ажлыг хилийн цэргийн 0285 анги, бусад мэргэжлийн байгууллагтай БОАЖЯамнаас ирсэн зөвлөмжий дагуу хамтран гүйцэтгэлээ.

МАНУТХГ-ын Хамагаалалтын Захиргаа